



“ПОВЕРЭД ЭЙ ДИ ЭМ” ХХК

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
ОКТАГОН крипто биржийн
2024 оны үйл ажиллагааны тайлан

АГУУЛГА

1. ОРШИЛ
2. САНХҮҮ
 - 2.1. Тайлант жилд ВХҮҮ-ийн орлогод нөлөөлсөн хүчин зүйл
 - 2.2. Гадаад дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломж
3. БҮТЭЭГДЭХҮҮН
 - 3.1. Бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэлт, төрөлжилт, өөрчлөлт
 - 3.2. Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт
4. ПРОГРАММ ХАНГАМЖ
 - 4.1. Программ хангамж, систем
 - 4.2. Технологийн гэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа.
 - 4.3. Биржийн нууцлал
 - 4.4. Аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт.
 - 4.5. Эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
5. ЭРСДЭЛ
 - 5.1. Сонирхолын зөрчилтэй хэлцэлд оролцогч тал
 - 5.2. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
 - 5.3. Дотоод аудитын ажлын тайлан
6. ДҮГНЭЛТ

1. ОРШИЛ

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрхээ авсан. “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн хувьцааны 50 хувийг “Поверэд” ХХК, 50 хувийг “Алтан Дорног Монгол” ХХК тус тус эзэмшдэг. “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 7 гишүүнтэй бөгөөд үүнээс 3 нь хараат бус гишүүн болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Төгөлдөр, гишүүнээр Н.Батбаяр, Т.Ганболд болон Ж.Дэлгэрсайхан нар томилогдсон. Харин Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр А.Энхбаяр, С.Өнөржаргал болон Ж.Хүнболд нар тус тус томилогдсон болно.

СЗХ-ны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 657 тоот тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 3.15-д заасны дагуу гараах агуулгын хүрээнд тайлангаа бэлтгэсэн болно. Үүнд:

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн орлогод нөлөөлсөн хүчин зүйлс
2. Санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх
3. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлт
4. Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт
5. Ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн дэг бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ
6. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл, тухайн хэлцэлд оролцогч талууд
7. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, дотоод аудитын ажлын тайлан
8. Бусад мэдээлэл

2. САНХҮҮ

2024 онд Биткойн \$100K давж шинэ үнэлгээнд хүрч зах зээл сэргэлт ирсэн боловч МУ-ын хувьд зах зээл 2022 оны уналтаасаа сэргэж чадаагүй хэвээрээ байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.2 дахь хэсэгт зааснаар санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах болон шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэхийн хүрээнд гараах мэдээллийг оруулсан болно.)

2.1 ВХҮҮ-ИЙН ОРЛОГОД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Октагон крипто биржийн орлогод гараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Тухайлбал:

2.1.1 Хууль, зохицуулалтын тогорхойгүй байдал

Сүүлийн жилүүдэд криптовалютын өсөлт, хэрэглээ нэмэгдэж, төр засаг энэ салбарыг хууль, эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлагатай гэж үзэж эхэлсэн. Үүний хүрээнд тогорхой дүрэм, журам боловсруулах оролдлого хийж байгаа боловч одоог хүртэл нэгдсэн бодлого, тогтвортой хууль эрх зүйн орчин бүрдээгүй хэвээр байна. Энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон криптовалютын арилжаа эрхлэгчдэд эргэлзээ төрүүлж, зах зээлийн үдэвхжил буурахад нөлөөлж байна.

Хэдийгээр криптовалют Монгол Улсад хууль ёсны гэж тооцогддог ч, бодлогын тогтвортой байдал хангалтгүй байгаа нь зах зээлд оролцогчдог тогорхой бус байдал үүсгэж байна. Төрийн байгууллагуудын зүгээс татварын зохицуулалт, хяналт шалгалтыг нэмэгдүүлэх талаар яригдаж байгаа нь бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулж, заримыг нь үйл ажиллагаагаа хумих эсвэл гадаадын биржүүд рүү шилжихэд хүргэж байна.

2.1.2 Банкны комплайнс бодлого

Монголын банкууд криптовалютын арилжаатай холбоотой гүйлгээнд хязгаарлалт тавьж байгаа нь дотоодын крипто биржүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хэрэглэгчдийг олон улсын платформууд руу шилжихэд хүргэж байна. Тухайлбал, зарим банкууд крипто бирж рүү шууд мөнгө шилжүүлэхийг хориглож, арилжааны орлогоо банкны дансандаа авахад хүндрэл үүсгэж байна. Үүнээс үүдэн хэрэглэгчид олон улсын Binance, OKX, Bybit зэрэг платформуудыг илүүд үзэж, P2P арилжаа хийх хандлага өндөр байсаар байна.

Энэ нөхцөл байдал нь дотоодын крипто зах зээлд сөрөг үр дагавар авчрах бөгөөд төлбөрийн шинэ шийдлүүдийг хөгжүүлэх шаардлагатай болж байна.

2.1.3 ОУ-ын зах зээлийн нөлөө

Олон улсын крипто зах зээлийн нөхцөл байдал Монголын дотоодын биржүүдэд шууд нөлөө үзүүлдэг бөгөөд хэрэв дэлхийн зах зээлд криптовалютын арилжааны идэвх сулрах эсвэл үнэ уналттай байвал Монголын арилжааны хэмжээ ч буурах хандлагатай байдаг. Энэ нь олон улсын хөрөнгө оруулагчид, томоохон сангуудын шийдвэр, макро эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч, Монголын крипто хэрэглэгчид ч зах зээлийн чиг хандлагыг дагаж хөдөлдөгтэй холбоотой. Ялангуяа, Bitcoin болон Ethereum зэрэг голлох криптовалютуудын үнэ унах үед арилжаа багасаж, зах зээлийн тогтворгүй байдал нэмэгддэг.

Гэхдээ үүний эсрэгээр, олон улсын крипто зах зээл өсөлттэй, идэвхтэй үед Монголын дотоодын крипто зах зээлд төдийлөн хүчтэй өсөлт ажиглагдахгүй байгаа нь хэрэглэгчдийн итгэл хангалттай сэргээгүй байгаатай холбоотой. Үүний гол шалтгаан нь дотоодын зах зээлд итгэлцэл сул, хууль эрх зүйн тогтвортой байдал хангалтгүй, мөн банкнуудын зүгээс тавьсан хязгаарлалт, төрийн бодлогын тодорхой бус байдал зэрэгтэй холбоотой. Монголын крипто сонирхогчид, арилжаачид гадаадын томоохон биржүүдэд илүү итгэх хандлагатай байгаа тул дотоодын зах зээл олон улсын чиг хандлагыг тэр дор нь дагаж өсөхгүй байна. Энэ нь дотоодын биржүүдийн хөрвөх чадвар, хэрэглэгчдийн итгэл, арилжааны гэд бүтэц хангалтгүй байгаагийн илрэл бөгөөд энэ салбарт илүү

тогтвортой бодлого, хэрэглэгчдэд итгэл төрүүлэх арга хэмжээнүүд шаардлагатай байгааг харуулж байна.

2.2 ГАДААД, ДОТООД ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТАХ БОЛОМЖ

Манай байгууллага 2024 онд санхүүгийн нөөцөө готоог эх үүсвэрээс татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэхэд анхаарч ажиллалаа. Түр хугацааны санхүүжилтийн өр төлбөрийн эргэн төлөлтийн хувьд бид үйл ажиллагаанаас бий болсон ашгаасаа төлөх боломжтой бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд готоог нөөц бололцоогоо бүрэн ашиглахын зэрэгцээ олон улсын хөрөнгө оруулалтын сувгуудыг судалж, хөрвөх чадвараа нэмэгдүүлэх стратегийг баримталж байна.

Түүнчлэн, бид крипто биржийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн идэвхийг сэргээх зорилгоор шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, арилжааны экосистемээ өргөжүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд олон улсын томоохон биржүүдтэй хамтран ажиллах, технологийн шинэчлэл хийх, стратегийн түншлэлүүдийг бэхжүүлэх алхмуудыг хэрэгжүүлж байна. Олон улсын хөрөнгө оруулалт татах чиглэлд тодорхой эерэг үр дүн гарч, хэлцлүүд амжилттай урагшилж байгаа бөгөөд эдгээр төслүүд 2025 онд эцэслэгдсэнээр Октагон биржийн үйл ажиллагаа эрс сайжирч, зах зээлд илүү өрсөлдөх чадвартай болох төлөвтэй байна.

3. БҮТЭЭГДЭХҮҮН

Октагон бирж нь хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн нэвтрүүлж, крипто арилжааны экосистемийг өргөжүүлж байна. Манай бүтээгдэхүүнүүд нь хөрөнгө оруулагчдад илүү ашигтай, аюулгүй, хүртээмжтэй шийдлүүдийг санал болгож, дижитал санхүүгийн боломжийг өргөжүүлэхэд чиглэгддэг.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.3 дах хэсэгт зааснаар Октагон крипто биржийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, өөрчлөлтийн хүрээнд дараах мэдээллийг боловсруулж бэлдсэн болно.)

3.1 Октагон крипто биржийн бүтээгдэхүүн үйлчилгээний шинэчлэл, өөрчлөлт, төрөлжилт

Октагон крипто бирж нь зөвхөн ADMC койн дээр арилжаа хийж, токеноор тогтвортой үйл ажиллагаа явуулсан хэвээр байна. Түүнчлэн Bitcoin network, Ethereum network, BSC network зэрэг сүлжээнд токен оруулж ирэх бүрэн боломжтойгоор серверээ ачаалсаар байна.

Хэдий крипто өвөл дотоодын зах зээлд үргэлжилсэн хэвээр байгаа ч дэлхий даяар криптовалютын хэрэглээ илүү практик хэрэглээнд чиглэж, технологийн хөгжлийг даган улам боловсронгуй болж байна. Хэрэглэгчдийн шунал, сэтгэл хөөрлөөс илүүтэйгээр бодит хэрэглээнд суурилсан гэд бүтцийн системүүд бий болж, крипто экосистем улам өргөжиж байна. Үүний нөлөөгөөр, санхүүгийн салбарт крипто төлбөрийн системүүд, DeFi платформууд, токенжуулалтын төслүүд илүү тогтвортой, үр ашигтай шийдлүүдийг санал болгож, хэрэглэгчдийн итгэлийг сэргээж байна.

Үүнтэй холбоотойгоор Октагон бирж өөрийн технологийг олон улсын томоохон биржүүдтэй холбохоор хэд хэдэн API хөгжүүлэлтийг амжилттай хийж, гэд бүтцээ улам хүчирхэгжүүллээ. Ингэснээр хэрэглэгчид илүү өргөн хүрээний арилжааны боломжуудыг ашиглах, олон улсын биржүүдийн ликвидитид шууд хандах боломжтой болж байна. Мөн гадны биржүүдтэй хамтран манай KYC технологийг ашиглах боломжийг бүрдүүлж, хэрэглэгчийн бүртгэл, баталгаажуулалтын процессыг илүү хялбар, аюулгүй болголоо. Энэ нь

Октагон биржийн олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт, стратегийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал алхам болж байна.

3.2 Хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлт

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.4 дэх хэсэгт зааснаар Октагон крипто биржийн хадгалж, удирдаж байгаа харилцагчийн виртуал болон мөнгөн хөрөнгийн тоон үзүүлэлтийн хүрээнд бэлдсэн болно.)

Октагон бирж гээр 2024 оны 12 сарын 31-ний байглаар нийт 43,254 харилцагч бүртгэлтэй байгаагаас ДАН-гаар баталгаажуулалт хийсэн 2,538 хэрэглэгч байна. Тэдгээрийг насны хувьд ангилж авч үзвэл 16-30 насны 972 хэрэглэгч, 30-45 насны 1,301 хэрэглэгч, 45 болон түүнээс дээш 265 хэрэглэгч байна. Мөн хүйсээр ангилж үзвэл 1,904 эрэгтэй хэрэглэгч, 634 эмэгтэй хэрэглэгчтэй байна.

Игэвхтэй буюу "Stake"-нд байгаа хадгалсан нийт 118 хэрэглэгчийн 750,532,607.64 ADMC байна.

Нийт хэрэглэгчийн хэтэвчний үлдэгдэл:

1. 5,394 хэрэглэгчийн 11,423,378,227.67 ADMC
2. 3,203 хэрэглэгчийн 447,654,395.60 MNT

4. ПРОГРАММ ХАНГАМЖ

Октагон бирж нь крипто арилжааны гэршилтэт технологийг хөгжүүлж, хэрэглэгчдэд найдвартай, хурдан, аюулгүй арилжааны орчин бүрдүүлэх зорилготой. Манай программ хангамж нь блокчэйн технологийн сүүлийн үеийн шийдлүүдийг шингээж, олон улсын стандартад нийцсэн байдлаар хөгжүүлэгдсэн.

Бид системийн аюулгүй байдал, арилжааны хурд, хэрэглэгчийн туршлагыг сайжруулах чиглэлээр тасралтгүй хөгжүүлэлт хийж, ОУ-ын биржүүдтэй API холболт хийж, арилжааны гэд бүтцийг өргөтгөсөн. Түүнчлэн, манай KYC технологи нь хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, бодит баталгаажуулалтыг хангах замаар крипто арилжааны ил тод, найдвартай байдлыг нэмэгдүүлж байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.5 дах хэсэгт зааснаар Ашиглаж буй программ хангамж, систем, мэдээлэл, технологийн гэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдал хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд гараах байдлаар тайлбарласан болно.)

4.1 Октагон крипто бирж дээр ашиглаж буй программ хангамж

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь Виртуал хөрөнгийн үйлчилгээнд Front-end flutter, Back-end Node.js болон Server Aws гэсэн програмуудыг ашиглаж байгаа болно.

“Front-end flutter” нь Google-ээс өөрийн гар утасны аппликэйшн үүсгэхэд зориулагдсан үнэ төлбөргүй, нээлттэй загвар бүхий UI “Front-end” технологи юм. 2017 онд гарсан “Flutter” нь хөгжүүлэгчдэд нэг кодын сан болон програмчлалын хэлээр гар утасны программ бүтээх боломжийг олгосон. Энэ чадвар нь IOS болон Android програмуудыг аль алиныг нь хялбар, хурдан бүтээх боломжийг олгодогдоороо давуу талтай учраас манай байгууллага ашигладаг.

“Back-end Node.js” нь JavaScript Engine (Жишээлбэл, V8 хөгөлгүүр) гээр ажилладаг, өргөтгөх боломжтой сүлжээний програмуудыг бүтээхэд зориулагдсан веб хөтчөөс гадуур JavaScript кодыг ажиллуулдаг нээлттэй эх сурвалжтай, cross платформтой, back-end JavaScript ажиллах орчин юм. Node.js нь хэрэглэгч веб хөтөч рүү хуудсыг илгээхээс өмнө динамик веб хуудас агуулгыг бий болгохын тулд сервер талын скриптүүд болон сервер талын скриптүүдийг бичихэд JavaScript ашиглах боломжийг хөгжүүлэгчид олгоно. Иймээс “Node.js” нь сервер болон клиент талын скриптүүдийн өөр хэлээр бус, программчлалын нэг хэлний эргэн тойронг веб программ хөгжүүлэлтийг нэгтгэсэн “JavaScript хаа сайгүй” парадигмыг төлөөлж чаддагаараа давуу талтай.

“Server Aws нь Amazon Web Services” (AWS) нь гэлхийн хамгийн өргөн цар хүрээтэй, түгээмэл ашиглагддаг үүлэн платформ бөгөөд гэлхий нийтийн хэмжээнд гата төвүүдээс 200 гаруй бүрэн боломжит үйлчилгээг санал болгодог. Хамгийн хурдацтай хөгжиж буй стартап, томоохон аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд зэрэг олон сая үйлчлүүлэгч зардлаа бууруулж, илүү уян хатан байдлаар илүү хурдан инновац бүтээх зорилгоор AWS-ийг ашиглаж байна.

4.2 Октагон бирж гээр ашиглаж буй технологийн гэд бүтэц болон түүний тасралтгүй найдвартай ажиллагаа

Октагон биржийн технологийн гэд бүтэц нь гараах 5 гэд хэсгээс бүрдэнэ. Үүнд:


1. Route 53 DNS
2. AWS VPC (private network zone)
 - a. AWS RDS multi Zone
 - b. Elastic Load balancer
 - c. Hashicorp vault
3. Elastic Kubernetes service
4. Fireblocks
5. Бусад

Эдгээр гэд бүтцийг тус бүрд нь авч үзвэл:

Route 53 DNS

“Amazon Route 53” бол өнгөр хүртээмжтэй, өргөтгөх боломжтой “Домэйн Нэрийн Систем” (DNS) веб үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээ нь хэрэглэгчийн хүсэлтийг AWS эсвэл суурин ажиллаж байгаа интернэт програмуудтай холбогдог.

Зогварчилгаа 1. Route 53 DNS



Эх сурвалж: ВХҮҮ, Поверэд Эй Ди Эм


AWS VPC (private network zone)

Октагон крипто бирж нь гараах системүүдийн тусламжтайгаар AWS дээр 24/7/365 ажилладаг. Үүнд:

а. AWS RDS multi Zone

Amazon RDS Multi-AZ-г байршуулахгаа Amazon RDS нь үндсэн мэдээллийн сан (DB)-г автоматаар үүсгэж, өгөгдлийг өөр AZ дахь жишээнд синхроноор хуулбарладаг. Системд алдаа гарсан тохиолдолд Amazon RDS нь гар ажиллагаагүйгээр автоматаар зогсох горимд шилжинэ.


Зогварчилгаа-2. AWS RDS Multi Zone



b. Elastic Load balancer

Ачааллыг тэнцвэржүүлэгч (ELB) нь нэг буюу хэд хэдэн боломжит бүсэд (AZs) зорилтот болон виртуал олон хэрэгслээр ирж буй программын траффикийг автоматаар хуваарилдаг.

Зогварчилгаа-3. Elastic load balancer




c. Hashicorp vault

“HashiCorp Vault” нь байгууллагуудын мэдээлэлд суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн тусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

Elastic Kubernetes service

Amazon Elastic Kubernetes Service (Amazon EKS) нь Kubernetes програмуудыг үүлэн сервер эсвэл газар дээр нь ажиллуулах масштабжуулах зориулалттай удирддаг контейнер үйлчилгээ юм.

График 1. Elastic Kubernetes service



Fireblocks

Манай байгууллагын хувьд Fireblocks-оос гарах үйлчилгээг авч байна. Үүнд:

1. Ашиглалт үйлчилгээний гэрээтэй Блокчэйн node,
2. Даатгал, ашиглалт үйлчилгээний гэрээ бүхий крипто хэтэвч,
3. Криптой гүйлгээний дүрмүүг тохируулж мэдэгдэл авах, нэмэлт баталгаажуулалт авах боломж.

Манай байгууллагын хувьд Chainalysis-оос KYT үйлчилгээг авч байна.

KYT - Know your customer буюу бүх гүйлгээг шалгаж илгээгч болон хүлээн авагч хэтэвч нь хар жагсаалтад орсон эсэх, тодорхой давтамжтай илгээж сэжигтэй үйлдэл хийж байгаа, мөнгө угаах буй эрсдэлтэй эсэх гэх мэт мэдээллийг бидэнд гаргаж өгнө.

4.3 Октагон крипто бирж дээр мэдээлэл хадгалалт, нууцлал

Октагон крипто бирж нь гараах программыг ашиглаж нууцлал аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Үүнд:

1. KYC : Үйлчлүүлэгчээ танин мэдэх (KYC) нь хөрөнгө оруулалтын салбарын хамгийн чухал стандарт бөгөөд үйлчлүүлэгчийнхээ хувийн мэдээллийг баталгаажуулах, үйлчлүүлэгчийнхээ хөрөнгө оруулалтын мэдлэг болон санхүүгийн мэдээллийг мэдэх боломжийг олгодог. Хэрэглэгч бүрд KYC хэрэгжүүлснээр хэн хэдэн төгрөгийн гүйлгээ хийж байгааг бүртгэж, улмаар мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

2. ДАН систем : “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем нь цахим орчинг бүх төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх бөгөөд хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй нягт уялдаатай ажиллах боломжтой нэгдсэн платформ юм.

3. Wallet Key Encrypted : Крипто бирж дээр бүртгэлтэй байгаа хэрэглэгч бүрийн “Wallet Key” буюу кодолсон хэтэвчийг шифрлэж нууцалснаар аль хэрэглэгчийн түлхүүр гэдгийг мэдэх боломжгүй болох юм.

4. Database Backup is Encrypted : Бид өөрсдийн мэдээллийн санг тогтмол хугацаанд өөр тийш хуулбарлан зөөж хадгалдаг бөгөөд тэрхүү мэдээллээ шифрлэж өгснөөр мэдээллээ алдах эрсдэлтэй хэдий ч тухайн мэдээллийг тайлж унших боломжгүй.

5. Amazon Firewall Rule : AWS Network Firewall гүрмийн бүлэг нь сүлжээний урсгалыг шалгах, зохицуулах олон дахин ашиглах боломжтой шалгуур үзүүлэлт юм. Зөвхөн зөвшөөрсөн байршлуудаас хандалт авах эрхтэй.

6. Amazon Audit Log : Сервер дээрх бүх үйлдлийг бүртгэж бичнэ.

7. Amazon S3 Encrypted Bucket : Amazon S3-ын анхдагч шифрлэлтийн тусламжтайгаар та “S3 Bucket” өгөгдмөл шифрлэлтийн зоримыг тохируулж өгснөөр бүх шинэ объектыг Bucket готор хадгалах үед шифрлэгдсэн болно. Объектуудыг AWS Key Management Service (AWS KMS) (SSE-KMS)-г хадгалагдсан Amazon S3 удирдгагч түлхүүрүүд (SSE-S3) эсвэл AWS KMS түлхүүрүүдээр сервер талын шифрлэлт ашиглан шифрлэдэг.

8. Hashicorp Vault : HashiCorp Vault нь байгууллагуудын мэдээлэл суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн тусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

Amazon S3 Encrypted Bucket : Amazon S3-ын анхдагч шифрлэлтийн тусламжтайгаар та S3 Bucket өгөгдмөл шифрлэлтийн зоримыг тохируулах боломжтой бөгөөд ингэснээр бүх шинэ объектыг Bucket готор хадгалах үед шифрлэгдсэн болно. Объектуудыг AWS Key Management Service (AWS KMS) (SSE-KMS)-г хадгалагдсан Amazon S3 удирдгагч түлхүүрүүд (SSE-S3) эсвэл AWS KMS түлхүүрүүдээр сервер талын шифрлэлт ашиглан шифрлэдэг.

Hashicorp Vault : “HashiCorp Vault” нь байгууллагуудын мэдээлэл суурилсан аюулгүй байдлын автоматжуулалт, үйлчилгээ болгон шифрлэлтийн тусламжтайгаар зөрчил, мэдээлэлд өртөх эрсдэлийг бууруулахад тусалдаг.

4.4 Октагон крипто биржийн аюулгүй байдалд хийлгэсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт,

Манай байгууллагын Эрсдэлийн Удирдлагын Бодлогын үндсэн зорилго нь “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг баримтлан Компанийн нийт үйл ажиллагаанд ажилтнууд, бизнесийн хөрөнгө болон санхүүгийн тогтвортой байдлыг хангуулах замаар аливаа эрсдэлээс хамгаалах, бидний харилцагчдын сэтгэл ханамжийг дүүргэхэд оршдог.

Эрсдэлийн Удирдлагын Бодлого нь манай Компанийн хамгийн гол эрх зүйн баримт бөгөөд нийт үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт болон чиглэл бүрийн эрх зүйн бүрэн баримтууд үндэслэдэг.

Эрсдэлийн удирдлагад суурилсан бодлогыг олон улсын стандартын дагуу хэрэгжүүлснээр бид “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн нэр хүндийг урт хугацаанд бататгаж, бидний харилцагчдыг аливаа санхүүгийн луйвар залилангаас сэргийлэх, олон нийтэд бидний үйл ажиллагааны талаар үнэн зөв ойлголт түгээх, бидний бизнесийн талаарх иргэдийн бизнес, санхүүгийн талаарх мэдлэгийг тогтмол дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Манай байгууллага Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд үйл ажиллагаа, систем, санхүү, хүрээлэн буй орчин, зах зээл, өрсөлдөгчийн гэсэн 7 ангилалд дотоод болон гадаад эрсдэлээ үнэлдэг болно. Октагон крипто биржийн хувьд гараах замаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэлийг илрүүлдэг. Үүнд:

1. Chainalysis KYT нь крипто валютын бүх хөрөнгийн тасралтгүй гүйлгээний хяналтыг гүйцэтгэдэг. KYT-ийг ашиглан өнгөр эрсдэлтэй үйл ажиллагааны үйлдлийг илрүүлэх
2. OFAC-ийн хоригийн жагсаалтад тодорхойлсон хаягаар гүйлгээ хийхээс урьдчилан сэргийлэх
3. Хакердсан болон ransomware-аас хадгаламжийг царцаах
4. ETH дансуудыг шалгах зэрэг боломжийг шалган ажилладаг болно.

4.5 Технологийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

“Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн хэмжээнд технологийн болон байгууллагын нийт үйл ажиллагаанд учирч болзошгүй дотоод болон гадаад хүчин зүйлээс хамаарсан бүх түвшний аливаа эрсдэл нь байгууллагын “Эрсдэлийн Удирдлагын Бодлого”-ын хүрээнд хэрэгждэг бөгөөд тус баримт бичгийн үндсэн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийг баримтлан компанийн нийт үйл ажиллагаанд ажилтнууд, бизнесийн хөрөнгө болон санхүүгийн тогтвортой байдлыг хангуулах замаар аливаа эрсдэлээс хамгаалах, бидний харилцагчдын сэтгэл ханамжийг дүүргэхэд оршдог.

Эрсдэлийн удирдлагад суурилсан бодлогыг олон улсын сайн туршлагын дагуу хэрэгжүүлснээр байгууллагын нэр хүндийг урт хугацаанд бататгаж, бидний харилцагчдыг аливаа санхүүгийн луйвар залилангаас сэргийлэх, олон нийтэд бидний үйл ажиллагааны талаар үнэн зөв ойлголт түгээх, бидний бизнесийн талаарх

иргээдийн бизнес, санхүүгийн талаарх мэдлэгийг тогтмол дээшлүүлэх учиртай билээ

Бид байгууллагын бүх түвшинг дараах зарчмын дагуу эрсдэл бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж ажилладаг. Үүнг:

- ◆ Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох,
- ◆ Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох,
- ◆ Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, дүгнэх,
- ◆ Эрсдэлийн эсрэг арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх ба эрсдэлд суурилсан ажлын соёлыг нэвтрүүлэн хэвшүүлэх.

Эрсдэлийг тодорхойлох болон үнэлэх, түүнийг бууруулах буюу хүлээн зөвшөөрөх түвшинг нь үйл ажиллагаагаас тасралтгүй, найдвартай хангахын тулд эрсдэл үнэлэх тусгай баримт бичигтэй бөгөөд технологийн үйл ажиллагааны хувьд ажилтнууд хангах эрхийн удирдлага, ажил үүргийн үүрэг харууцлага, системд хэрхэн ажиллах гээд бүх аюулгүй байдал хяналтын дор өдөр тутам хэрэгждэг.

ЭРСДЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

Бид байгууллагын бүх түвшинг учирч болохуйц эрсдэлийг илрүүлж, үнэлснээр дараа дараагийн шийдвэрүүдийг гаргах бөгөөд холбогдох баримт бичгийн дагуу эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшинг бууруулж бүх оролцогч талд мэдээлж ажиллах зарчмыг баримталдаг.

-
- Эрсдэлд бууруулах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээг тодорхойлох;
 - Эрсдэлийн хариу арга хэмжээ авах эсэх;
 - Төрөл бүрийн эрсдэлийн хариу арга хэмжээний хувилбараас сонгох;
 - Эрсдэлийн хариу арга хэмжээний хувилбарыг ач холбогдлоор нь эрэмбэлэх;
 - Эрсдэл нэг бүрийг хариуцах ажилтанг хуваарилах, хариуцуулах зэргээр ажиллаж байна.

Түүнчлэн бид эрсдэлд суурилсан арга хэмжээний баримт бичгийг боловсруулахдаа дараах үйл явцыг ханган ажилладаг. Үүнг:

1. Эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй үйл явцын таслан зогсоох;
2. Бизнесийн боломжийг ашиглах зорилгоор эрсдэлийг нэмэгдүүлэх эсвэл үүрэх;
3. Эрсдэлийн анхдагч болон гараалах эх үүсвэрийг арилгах;
4. Магадлалыг өөрчлөх;
5. Үр дагаврыг өөрчлөх;
6. Бусад оролцогч талуудтай эрсдэлийг харилцан хэлэлцэх;
7. Бүх талын мэдээлэлд үндэслэн шийгвэр гаргаж эрсдэлийг даван туулах шийгвэр гаргах ба бүртгэлд оруулах.

Манай байгууллагын хувьд Эрсдэлийн харуу арга хэмжээ нь сонгож авсан эрсдэлийн харуу арга хэмжээний хувилбарыг хэрэгжүүлэх ач холбогдолтой юм. Харуу арга хэмжээнд гараах мэдээллийг багтаах нь чухал бөгөөд үүний дагуу холбогдох баримт бичгийг үйлдэж, хэрэгжүүлэхийн төлөө зорьж ажиллагаа болно. Үүнг:

1. Харуу арга хэмжээний хувилбарыг сонгосон шалтгаан, хүлээгдэж буй үр нөлөө
2. Эрсдэлийн харууцагч ажилтны хувийн харууцлага болон хэрэгжүүлэхэд хүлээн үүргийн цар хүрээ
3. Хэрэгжүүлэхээр дэвшүүлж буй цогц ажиллагаа
4. Болзошгүй тохиолдлыг багтаасан шаардлагатай нөөц
5. Гүйцэтгэлийн хэмжүүр
6. Тайлагнах болон мониторингийн ажиллагаанд тавигдах шаардлага
7. Хугацаа, хуваарийн матрикс зэргийг тусгасан эрсдэл үнэлэх хүснэгт хэлбэрийн баримт бичигтэй болно.

5.Комплайнс

Крипто зах зээл нь өндөр өгөөжтэй боломжуудыг санал болгодог хэдий ч дотоод болон гадаад зах зээлийн хэлбэлзэл, зохицуулалтын өөрчлөлт зэрэг олон төрлийн учирч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдал оршин байдаг өвөрмөц орчин юм.

Октагон бирж нь хэрэглэгчдийн хөрөнгийн аюулгүй байдлыг хангах, системийн найдвартай ажиллагааг сайжруулахын тулд олон улсын стандартад нийцсэн хамгаалалтын арга хэмжээнүүдийг тасралтгүй хэрэгжүүлж байна. Манай байгууллагын нийт үйл ажиллагааны бүх түвшин, тэр дундаа технологийн аюулгүй байдал нь тодорхой стандартын дагуу баримт бичиг, нийт ажилтан болон байгууллагын удирдлагын хэмжээнд үүрэг хариуцлага, өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагаа, системийн хөгжүүлэлт, сайжруулалт, зах зээлийн янз бүрийн нөхцөл байдалд тогтвортой, найдвартай ажиллах бүхий л цогц бодлого, арга хэмжээг авахын төлөө хичээн ажиллаж байна. Манай байгууллагын хэлтэс нэгж, удирдлага болон хүний нөөцийн бодлого тогтвортойгоос гадна ажилтнуудаг хүргэх мэдлэг, мэдээллийг МАБУТ-ны стандартын дагуу тогтмол ханган ажиллаж байна.

Бид зохицуулах гээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, шаардлагатай баримт бичгийг цаг тухайг нь үйлдэж, хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг бөгөөд байгууллагын комплайнсын тал дээр хөндлөнгийн албан ёсны эрхтэй байгууллагаар Аудитын хяналт, шалгалтын үйл ажиллагааг жил бүр тогтмол хэрэгжүүлж байгаа болно.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.6 дах хэсэгт зааснаар сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлд оролцогч талуудын хүрээнд)

5.1 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд оролцогч тал

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 03 тоот тогтоолын Хавсралт 01-ээр Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журмыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс, Компанийн

дүрэмдээ нийцүүлэн баталсан. Тус журмаар компани гуравдагч этгээдтэй их хэмжээний хэлцэл хийх журам, компанийн нэгдэл гэх компанцуг болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хэлцэл хийх журам, түүнчлэн сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй нөхцөл болон бусад сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Компани нь өөрийн байгуулсан сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүн зэрэг мэдээллийг тухай бүр мэдээлдэг бөгөөд 2024 онд тус төрлийн хэлцэл хийгдээгүй байна.

(Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.15.7 дах хэсэгт зааснаар эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, готоод аудитын ажлын тайлангийн хүрээнд гараах мэдээллийг оруулсан болно.)

5.2 Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт

“Поверэд Эй Ди Эм” ХХК нь өнгөрсөн 2022 оны есдүгээр сард виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын ISO 27001:2013 олон улсын стандартыг нэвтрүүлсэн бөгөөд гурав дахь жилдээ хэрэгжүүлээд явж байна. Бид уг стандартын хүрээнд байгууллагын готоод болон гадаад орчинд мэдээллийн аюулгүй байдлын бүрэн хангаж ажиллахын төлөө ажиллаж байна.

Манай байгууллага эрсдэлийн удирдлагын бодлого болон готоод аудитын журмыг баримт бичигт тусгасны дагуу арга хэмжээнүүдийг байгууллагын орчинд бүхэлд нь авч хэрэгжүүлдэг болно.

Эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийн хувьд нийт ажилтнууд өөрсдийн системийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал болон нийт ажлын процессыг боловсруулан батлуулахдаа үндэслэл болгон ажилладаг. Эрсдэлийн удирдлагын системийн талаар нийт ажилтнуудын дунд хуралдах байдлаар түгээж, системд учирч болзошгүй асуудлыг 7 хоног тутмын ажлын Мягмар гарагт тогтмол хөгжүүлэлт болон үйл ажиллагааны хэлтсээрээ удирдлагын төлөөллөөр ахлуулан хуралддаг бөгөөд энэхүү тайлангийн 4.5 Технологийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэсэгт дэлгэрэнгүй дурдсан билээ.

5.3 Дотоогын аудитын ажлын тайлан

“Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн 2024 оны Дотоог аудитын ажлын - хүрээнд ажилчдаас 5 хүний бүрэлдэхүүнтэй баг томилон жилийн үйл ажиллагааны 2 ба 4 дүгээр улиралд хэлтэс хоорондоо харилцан туршлага солилцох, хэлтэс хоорондын харилцан хамаарлыг ойлгох, өмнөх ажлаа дүгнэх зорилгоор дотоог аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Дотоог аудитын үйл ажиллагааны хувьд Технологийн болон Үйл ажиллагааны хэлтэс, Удирдлагын хэлтэс гэсэн үндсэн 3 хэлтэст гараах баг бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Үүнд:

1. Дотоог аудитын багийн ахлагч, “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Дотоог хяналт, эрсдэлийн удирдлага хариуцсан менежер Б.Элбэгжаргал
2. Хоёрдугаар аудитор, “Поверэд Эй Ди Эм” ХХК-г хуулийн зөвлөгөө үзүүлэгч Б.Итгэл
3. Гуравдугаар аудитор, “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Мэдээллийн технологийг хариуцаж ажиллагааг Г.Тэргэл
4. Дөрөвдүгээр аудитор, “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Комплайнс хариуцсан ахлах менежер Ө.Хишигбаяр
5. Тавдугаар аудитор, “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Харилцагчийн үйлчилгээ хариуцсан менежер Д.Агилгүй нар тус бүр Дотоог аудитын төлөвлөгөөний дагуу ажилласан.

“Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн хувьд байгууллагад авч хэрэгжүүлэх үйл явцыг тогтмол давтамжтай хугацаанд ажил үүргийн хуваарийн дагуу хэрэгжүүлдэг. Бид 2023-2024 оны авч хэрэгжүүлэхээр тусгасан 3 бүлэг бүхий нийт 12 ажлыг шат дараатайгаар амжилттай хэрэгжүүлсэн гэж үзсэн бөгөөд өнгөрсөн 2024 оны хувьд байгууллагын үйл ажиллагаа дотоог болон гадаад зах зээлийн тогтмол, өсөлт багатай нөхцөл байдлаар хамаарч харьцангуй тогтонги байдалд Дотоог аудитын үйл ажиллагааг өмнөх туршлага дээр үндэслэн хийж гүйцэтгэсэн. “Дотоог аудит хийх 2024 ажлын төлөвлөгөө”-г газар дээрх шалгалтын үеэр биечлэн танилцуулсан болно.

Дотоог аудитын багийн ахлагч, “Поверэд Эй Ди Эм” ХХК-ийн Дотоог хяналт, эрсдэлийн удирдлага хариуцсан менежер Б.Элбэгжаргалын хувьд хоёрдугаар улиралд буюу 2024 оны 05 сарын 21-ний өдөр Технологийн хэлтэст хийсэн готоог аудитын үйл ажиллагааг нийт 13 шалгуурын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

2023 онд тус агуулгын дагуу технологийн хэлтэст хийсэн готоог аудитын үйл ажиллагааны хүрээнд гаргасан нийт 5 зөвлөмжийн хэрэгжилттэй ахин танилцахад тэдгээрээс 3 зөвлөмжийг тэр даруйд нь хийж гүйцэтгээгүй хэдий ч орлож болохоор, тухайн зөвлөмжийг хангаж чадахуйц арга хэмжээг авч явж байсан тул нэмэлтээр ахиад зөвлөмж гаргаагүй болно. Өмнөх 2023 онд тус хэлтэст 2 ба 4-р улиралд готоог аудитыг тус шалгуурын хүрээнд салгаж хийж байсан бол энэ удааг 2-р улиралд нэгтгэсэн байдлаар хийж гүйцэтгэлээ. Учир нь тус агуулгын хувьд ажилтан албан хаагчид ажлын байран дээр тасралтгүй, хэвийн ажиллаж байснаас гадна шалгагч аудиторын өмнө нь шалгасан туршлага дээр үндэслэн лавлах болон шалгах түвшинд илүү тодруулах хэлбэрээр гүйцэтгэсэн нь ажлын байрны тав тухад сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр шалгалтаа хийх үндэс болсон. Түүнчлэн Технологийн хэлтсийн хувьд эдгээр шалгууруудаар өмнө нь шалгагдсан, ажлын үйл ажиллагааны хувьд холбогдох баримт бичиг, процессын дагуу ажиллаж, МАБ-ыг хангасан хэвээр байсан тул нэмэлтээр огт байгаагүй эсвэл огт мэдлэг, мэдээлэлгүй зүйл илрээгүй юм.

Дотоог аудитын багийн бусад бүрэлдэхүүний хувьд төлөвлөгөөний дагуу дөрөвдүгээр улиралд 7 хоног Лхагва гарагт өөрсдийн хуваарийн дагуу шалгуур үзүүлэлтээр үйл ажиллагаа явуулсан нь долоо хоног бүрийн Даваа болон Мягмар гарагт Үйл ажиллагаа хэлтэс болон удирдлага, Технологийн хэлтэс болон удирдлага гэсэн хэлтсийн хурлыг тус бүрдээ хийж гүйцэтгэдэгтэй уялгаж байгаа юм.

МАБУТ-ны ISO 27001 стандартын готоог аудиторын баг бүрэлдэхүүн дөрөвдүгээр улиралд жилийн ажлаа нэгтгэн дүгнэх зорилготойгоор хэлтэс хооронд хяналт шалгалт хийх ажлын явцад байгууллагын гадаад болон готоог орчинд ноцтой “Үл тохирол” гараагүй бөгөөд үйл ажиллагаа болон технологийн хэлтсийн хувьд цөөн тооны зөвлөмжийг гаргасан болно.

Тэдгээр зөвлөмжийн дагуу бид 2025 онд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тасралтгүй сайжруулах үүнээс гараагийн дотоод аудитын хяналт шалгалтын ажлаар тэдгээр зөвлөмжийн биелсэн эсэх дээр хяналт тавих болно.

Бид жил бүрийн эхний улиралд багтаах буюу дөрөвдүгээр сарын эхний 7 хоногт тухайн жилийн Дотоод аудитын төлөвлөгөөг гаргадаг бөгөөд 2025 оны хувьд жилийн үйл ажиллагааны хүрээнд ТУЗ-ийн эхний улирлын хурлын гараагаар удирдлагуудаар батлуулах юм. Дотоодын аудитын шалгалтын үйл ажиллагааг байгууллагын орчинд дотоод болон гадаад зах зээлийн нөхцөл байдал, үйл ажиллагааны тасралтгүй байдал, хууль эрх зүйн хүрээнд үндэслэн төлөвлөгөөний дагуу хийх болно.

6. ДҮГНЭЛТ

Октагон крипто бирж нь хоёр дахь жилдээ гараалан гомоогын зах зээлд уналттай, тогтворгүй нөхцөл байдлыг гаван туулж, үйл ажиллагаагаа тогтвортой хадгалсаар байна. Гэсэн хэдий ч бид 2025 оныг өөдрөгөөр харж, 2024 онд эхэлсэн крипто зах зээлийн сэргэлт цаашид үргэлжлэх бөгөөд олон улсын түвшинд эерэг хандлага гавамгайлна гэдэгт итгэлтэй байна. Дэлхийн крипто салбарт технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын өсөлт, зах зээлийн итгэл сэргэж буй олон нааштай дохио ажиглагдаж байна.

Мөн бид дВиртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчдийн (ВХҮҮ) талаарх шинэ хууль, дүрэм журам батлагдахаар байгаа нь гомоогын зах зээлийн сэргэлтийг хурдасгаж, гомоог болон гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чухал үйл явдал болно. Энэхүү эрх зүйн шинэчлэл нь крипто зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжиж, салбарын оролцогчдог илүү тодорхой, найдвартай орчныг бүрдүүлнэ гэдэгт найдаж байна.

Эдгээр хөгжлийн хандлагатай уялдуулан Октагон бирж нь системийн дэг бүтэц, экосистемээ сайжруулах чиглэлд Олон улсын крипто биржүүдтэй уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажилласан. Урт хугацааны уйгагүй хөдөлмөрийн үр дүнд 2025 онд бид платформоо олон улсын жишигт нийцүүлэх, хэрэглэгчдийн туршлагыг сайжруулах, арилжааны боломжуудыг өргөжүүлэх чиглэлээр томоохон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2024 онд Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос Октагон биржийн үйл ажиллагаанд аудит хийгдсэн бөгөөд бид тус шалгалтыг амжилттай давж, системийн найдвартай ажиллагаа, хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлд сайжруулалт хийх шаардлагатай талбаруудыг тодорхойлон, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн болно. Аудитын үр дүнд бид системийн тогтвортой байдал, эрсдэлийн удирдлагыг шинэ түвшинд гаргах бодлогын өөрчлөлтүүдийг хийж, хэрэглэгчдийн хөрөнгийн хамгаалалтыг улам бүр нэмэгдүүлэх шийдлүүдийг боловсруулсан.

Манай байгууллага виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хууль, зохицуулалтын шаардлагуудыг бүрэн хангаж,

хэрэглэгчдийн өмч хөрөнгийн найдвартай байдал, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бүхий л арга хэмжээг аван ажиллаж байна. Бид мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартыг дагаж мөрдөхөөс гадна системийн доголдолгүй, тасралтгүй ажиллагааг хангахад онцгой анхаарч, крипто арилжааны экосистемээ илүү найдвартай, тогтвортой болгохоор зорьж байна.

Цаашид виртуал хөрөнгийн үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг хянах, үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэхээс гадна байгууллагын дотоод болон гадаад орчны бодлого, журмыг шинэчилж, аюулгүй байдлыг хамгийн өндөр түвшинд байлгахыг эрхэмлэнэ. Октагон бирж нь Монголын крипто зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих, хэрэглэгчдэд аюулгүй, найдвартай арилжааны орчин бүрдүүлэх, олон улсын стандарттай хөл нийлүүлэн алхах зорилготойгоор үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн өргөжүүлэх болно.